

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 2-3

**1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны
үйл ажиллагааны тайлан сонсох** 2-3

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 29-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 09 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэбат;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Б.Бейсен, М.Ганхүлэг, С.Зулххар;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа;
Тасалсан: Х.Булгантуяа, Б.Түвшин.*

Нэг.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн Б.Алтанхуяг, Т.Баясгалан, Ш.Зориггоо, Ж.Гэрэлмаа, Н.Одонгуа, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга Ц.Сарантуяа, мөн албаны аудитор Н.Хишигсүрэн, З.Үнэнбат, нягтлан бодогч-аудитор Б.Отгонжаргал, судалгааны ажилтан О.Энхзаяа, Д.Отгонжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Тамгын газрын дарга М.Нармандах, мөн газрын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Худалдан авалт гэрээлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ганцэцэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Ц.Хосжаргал, ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитор М.Пагмадулам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр, Үнэлгээ, мониторингийн газрын референт Б.Энхмаа нар байлцав.

Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан уг асуудлыг хойшлуулах талаар санал хэлж, Байнгын хорооны дарга Л.Энхнасан хойшлуулсан талаар мэдэгдэв.

Хуралдаан 16 минут үргэлжилж, 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 14 цаг 25 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 29-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон
“Их эзэн Чингис хаан” танхим,
14 цаг 09 минут

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Л.Энхнасан: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн оролцож байна.

Өнөөдөр өвчтэй байгаа, хүндэтгэх шалтгаанаар Хөххүүгийн Болормаа гишүүн гадаад томилолттой байгаа Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн. Мөн Казакстаны Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд ажилтай байгаа, чөлөө хүссэн Цэндийн Баатархүү гишүүн, Буланы Бейсен гишүүн, Сархадын Зулхар гишүүн нар чөлөөтэй байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,4 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг сонсох болно.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа орье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.1.10-ын Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр сонсоно гэж заасны дагуу Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг Нийгмийн бодлогын байнгын хорооны өнөөдрийн хурлаар сонсож байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг сонсож эхэлье.

Ажлын хэсгийг оруулъя. Сайд ирж байна уу. Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Алтанхуяг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Баясгалан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Зоригоо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Гэрэлмаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Одонгуа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн, Сарантуяа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, Хишигсүрэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны аудитор, Үнэнбат Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны аудитор, Отгонжаргал Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны аудитор, Энхзаяа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны судалгааны ажилтан, Отгонжаргал Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны судалгааны ажилтан, Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Тамгын газрын дарга, Ариунсайхан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын

дарга, Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, мөн Үндэсний аудитын газраас Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Хосжаргал аудитын менежер, Эрдэнэцог ахлах аудитор, Пагмадулам аудитор нар ирсэн байна. Сайддыг оруулаарай.

Тайланг Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан танилцуулна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээг та бүхэнд хүргүүлсэн болно.

Хуралдаан эхэлчихсэн байгаа. Сайд аа, танилцуулгаа эхлүүлнэ үү. Сайдын микрофоныг өгнө үү.

Т.Мөнхсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1.2-т эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хороог тухайн асуудлаар мэргэшсэн шинжээч, судлаач, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагчийн оролцоотой байгуулж ажиллах журмыг батлах, холбогдох шийдвэрийг техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн гаргах гэж заасан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 8 дугаар сарын тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Техникийн хорооны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэйгээр, хорооны ажиллах журмыг баталж техникийн хорооны

орон тооны бус 5 гишүүний сонгон шалгаруулалтыг 2023 онд нээлттэй зарласан хэдий ч зөвхөн 3 нэр дэвшигч материал ирүүлсний улмаас Техникийн хороо бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах боломж бүрдээгүй.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаас Техникийн хорооны бүрэлдэхүүн ажиллах журмыг шинэчлэн батлах үүргийг Ажлын албанд өгсний дагуу тус албанаас дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Нэг. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 3 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий ...

Л.Энхнасан: Жудагийн Баярмаа гишүүн орж ирлээ. Сайд мэдээллээ хийх үү. Бэлэн биш бол хойшлуулах уу.

Т.Мөнхсайхан: Харин нэг удаа хойшлуулах хүсэлтэй байна.

Л.Энхнасан: Хурлыг хойшлууллаа.

14.25 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ